



Татварын талаарх илэн далангүй яриа

Татварын шинэтгэл хийх оролдлого өрнөж байна



Засгийн газар татварын багц хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, зарим хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн бариад байна. Үүнийг УИХ-ын намрын чуулганаар хэлэлцэх юм.

Хуулийн төсөл нь энэхүү цуврал нийтлэлийн анхны дугаарт дурдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэж байна. Үүнд:

1. Шинээр ажлын байр бий болгож, бизнес эрхлэгчдийн татварын дарамтыг бууруулах замаар Монгол улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх
2. Татварын хэмжээг багасган, ажиллах хүчний зардлыг бууруулснаар ажиллах хүчинд ногдох татварын дарамтыг бууруулах
3. Татварын албаны үйл ажиллагааг хөнгөн шуурхай, татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлдэг байх төвшинд хөгжүүлснээр татварын хуулийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг бууруулах
4. Татварын баазыг өргөтгөн далд эдийн засгийг бууруулах
5. Татварын ялгавартай байдлыг арилгаж, дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих
6. Татварын тогтолцоог зөв гольдролд оруулснаар санхүүгийн зохистой орчныг бий болгох.

Засгийн газрын хуралдаан, яамд болон бусад холбогдох байгууллагын ажлын хэсгийн хуралдаанаар энэхүү хуулийн төслийг олон удаа хэлэлцсэний дүнд дараах хуулийн төслүүдийг шинэчлэн найруулаад байна. Үүнд:

- Хуулийн этгээдийн орлогын албан татварын хууль
- Хүн амын орлогын албан татварын хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Онцгой албан татварын тухай хууль
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль

Хүчин төгөлдөр байгаа 5 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар өргөн бариад байна. Үүнд:

- Татварын ерөнхий хууль
- Захиргааны хариуцлагын тухай хууль
- Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль
- Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн хууль
- Гаалийн тарифын тухай хууль

Дээрх зорилтуудыг дэмжих болон Монгол улсын эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсруулаад байна. Уг хуулийн төслийг баталснаар бизнес эрхлэгчдийн татварын дарамт буурах юм. Улмаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй бүх бизнес эрхлэгчдийн дунд өрсөлдөөн бий болж тэдний олон улсад өрсөлдөх чадвар дээшлэх юм.

Татварын багц хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, зарим хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд орсон зарим заалтуудын дэлгэрэнгүйг дараагийн дугаартаа нийтэлнэ.

Дээрх хуулийн төслийн Монгол, Англи хувийг дор дурдсан вэб хаягаас үзэж болно.

Энэхүү мэдээлэл нь татварын шинэтгэлийн талаар нийт ард иргэдийн санаа бодлыг сонсох зорилгоор Сангийн яам, Үндэсний Татварын Ерөнхий Газраас явуулж буй цуврал хэлэлцүүлгийн наймдугаар хэсэг юм. Та бүхэн уг цувралын электрон хувилбарыг “Нээлттэй засаг” вэб сайт (www.open-government.mn), Сангийн яамны вэб сайт (www.mof.pmis.gov.mn), УТЕГ-ын вэб сайт (www.mta.mn)-аас үзэж, саналаа ирүүлж болно.